



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар Д/478

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.6.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Хэнтийн намрын ногоон өдрүүд-2023” нэгдсэн арга хэмжээг 2023 оны 9 дүгээр сарын 26-аас 2023 оны 9 дүгээр сарын 27-д “Чингис хотод” зохион байгуулахад 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.


2.Арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, арга хэмжээг зохион байгуулах зардлын тооцоог гуравдугаар, журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн хэсгийн ахлагч (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын 19-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Э. Мөнх-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Ж. Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Н. Зоригтбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

С. Нямдаваа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Г. Ариунчимэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн

М. Шүрэнцэцэг

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

Ч. Пүрэвдорж

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Г. Мөнх-Эрдэнэ

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргийн үүрэг гүйцэтгэгч

Г. Батгэрэл

“Хэнтий-Ус” ХХК-ий захирал

Т. Зулбаатар

Соёл урлагийн газрын дарга

О. Гомбобаатар

“Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ-ын захирал

Л. Мэндбаяр

Эрүүл мэндийн газрын дарга

Э. Жавхлантөгс

Цагдаагийг газрын дарга

С. Болд

Багануур Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээний төрийн өмчит хувьцаат компанийн Хэнтий Цахилгаан Түгээх Сүлжээ салбарын дарга



Аймгийн Засаг даргын 2023  
оны 09 дугаар сарын 19-ны  
... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

## “ХЭНТИЙН НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2023” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2023.08.30

Чингис хот

### Нэг. Удирдамжийн зорилго

Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгийн бизнес эрхлэгчид, малчид, тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилан таниулах, бизнесийн түншлэлийг тогтоох, хүн амыг чанартай, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг тодруулахад чиглэгдэнэ.

### Хоёр. Хугацаа

“Хэнтийн Намрын ногоон өдрүүд-2023” нэгдсэн арга хэмжээ 2023 оны 09 дүгээр сарын 26-27-ны өдөр Чингис хотын төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдана.

### Гурав. Үзэсгэлэн худалдааны төрөл, шалгаруулах журам

“Хэнтийн Намрын ногоон өдрүүд-2023” нэгдсэн арга хэмжээнд “Эрүүл хүнс-2023”, “Шинэ ургац-2023”, “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаа тус тус зохион байгуулагдана.

“Эрүүл хүнс-2023” үзэсгэлэн худалдаанд шилдэг Сүү, сүүн бүтээгдэхүүн, Мах, махан бүтээгдэхүүн, Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гэсэн төрлөөр тус бүр 2, нийт 6 шалгаруулна.

“Шинэ ургац-2023” үзэсгэлэн худалдаанд оролцогчдоос Шилдэг ногоочин, даршилсан ногоо, боловсруулсан жимс, жимсгэнэ төрлөөр тус бүр 1-г нийт 3 төрлөөр шалгаруулна.

“Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанд шилдэг Мод, модон эдлэл, Гар урлал болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүн, Оёмол бүтээгдэхүүн, Арьс ширэн эдлэл, Брэнд бүтээгдэхүүний багц, Шинэ санаа шилдэг бүтээл зэргийг шалгаруулна.

### Дөрөв. Сум сурталчилах арга хэмжээ


“Хэнтийн намрын ногоон өдрүүд-2023” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хэрлэн, Биндэр, Дархан сумдууд орон нутгийнхаа онцлогийг харуулсан сум сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

### Тав. Хамрах хүрээ

Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулдаг сум, тосгон, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд.

### Зургаа. Гаргах үр дүн

Төв суурин газрын иргэд хөдөлмөрчдийг эрүүл, аюулгүй экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангаж, үйлдвэрлэгчид харилцан туршлага солилцож, иргэдийн бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээ болон орлого нэмэгдэж нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болсон байна.



Аймгийн Засаг даргын 2023  
оны 09 дугаар сарын 19-ны  
... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

**“ХЭНТИЙН НАМРЫН БАЯР-2023” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ	
				Нэгж мян/төг	Бүгд үнэ Мян/ төг
1	Цом	ш	1	300,000	300,000
2	Өргөмжлөл	ш	4	35,000	140,000
3	Шилдэг сум I байр		1	400,000	400,000
4	Шилдэг сум II байр		1	350,000	350,000
5	Шилдэг сум III байр		1	300000	300,000
6	“Эрүүл хүнс-2023” үзэсгэлэн худалдаа				1,110,000
7	“Шинэ ургацын баяр-2023” үзэсгэлэн худалдаа				660,000
8	Нэг суурин нэг бүтээгдэхүүн				1,180,000
9	Байгал орчны нэрэмжит шагнал		1	100,000	100,000
10	Бусад зардал				460,000
<b>НИЙТ ДҮН:</b>					<b>5,000,000</b>

**“ХЭНТИЙН НАМРЫН НОГООН ӨДРҮҮД -2023” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНД  
ИДЭВХ САНААЧИЛГАТАЙ ОРОЛЦСОН СУМДЫГ  
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ.**

2023.08.30

Чингис хот

**Нэг. Зорилго**

Аймаг орон нутгаас зохион байгуулж буй арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцож сум орноо сурталчлан нутгийн брэнд бүтээгдэхүүнээ олон нийтэд таниулах, худалдан борлуулах аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулахад бусдыгаа манлайлан оролцсон сум, хамт олныг дэмжихэд чиглэгдэнэ.

**Хоёр. Шалгуур үзүүлэлт**

1.“Нэг суурин нэг бүтээгдэхүүн”, “Эрүүл хүнс-2023”, “Шинэ ургац-2023” зэрэг үзэсгэлэн худалдааг сум орон нутагтаа зохион байгуулж тайлан ирүүлсэн байх.

2.Сум орон нутгийн танилцуулгатай байх.

Онцлог брэнд бүтээгдэхүүн нь хаяг шошго, үйлдвэрлэсэн огноо, зориулалтын сав баглаа боодолтой байх.

3.Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдаалж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд нь худалдаа үйлчилгээ хийх нэг өнгийн хувцасаар жигдрэх, зориулалтын малгай, бээлийтэй байх ба амны хаалт, гар ариутгагчтай байж байнгын ариутгал хийж ажиллах.

4.Сумдын жагсаал болон бусад арга хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттай оролцох.

**Гурав. Дүгнэх журам шагнал**

Шалгаруулалтыг салбар комисс явуулах ба дээрх шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан дүгнэнэ. Идэвх санаачилгатай, зохион байгуулалттай оролцсон сумдыг 1,2,3 дугаар байр эзлүүлэн цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

**Дөрөв. Тавигдах шаардлага**

“Нэг суурин-нэг бүтээгдэхүүн”, “Эрүүл хүнс-2023”, “Шинэ ургац-2023” нэгдсэн арга хэмжээ 2 өдөр үргэлжлэх тул бэлтгэлийг сайтар хангаж, бүтээгдэхүүний нөөцтэй ирэх. Үзэсгэлэн худалдаанд оролцогчдын бүтээгдэхүүн тээвэрлэх, ирэх очих зардлыг тухайн сум орон нутаг болон иргэн, аж ахуйн нэгж өөрсдөө хариуцна.

## “ЭРҮҮЛ ХҮНС-2023” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ЖУРАМ

2023.08.30

Чингис хот

### Нэг. Зорилго

“Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийг сурталчлан таниулах хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, хөдөлмөрийг нь үнэлэх, аймаг сумдын шилдэг бүтээгдэхүүнийг тодорхойлох, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүний амт, чанарыг олон нийтэд сурталчлан таниулах, худалдан борлуулах зорилготой.

### Хоёр. Үзэсгэлэн худалдаанд оролцогчдод тавигдах шаардлага

1. Үзэсгэлэн худалдаанд оролцож буй иргэн, аж ахуйн нэгж нь эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан, сав, баглаа, боодолтой, таних тэмдэг бүхий ялгах энгэрийн тэмдэг, өөрийн бараа бүтээгдэхүүний шинж чанар, давуу талуудыг тодорхойлсон танилцуулга, үзүүлэн зурагт самбар зэргийг бэлдэж хүнсний худалдаа үйлчилгээ явуулах зориулалтын хувцас, малгай, бээлийтэй худалдаа үйлчилгээ явуулсан байх.

### Гурав. Шалгаруулах журам, шагнал

Эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүн бэлтгэх зорилгыг хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг хангасан байна.

#### Үүнд:

1. Бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүн нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байна.
2. Үзэсгэлэн худалдааны шалгаруулалтад оролцуулах хүнсний бүтээгдэхүүн нь хаяг шошго, үйлдвэрлэсэн огноо, зориулалтын сав баглаа боодолтой байна.
3. Чанар стандартын шаардлага хангасан сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүнийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаана.

### Дөрөв. Тавигдах шаардлага

Үзэсгэлэн худалдаанд оролцох аж ахуйн нэгж, иргэд нь бүтээгдэхүүний нөөцтэй, зах зээлд бүтээгдэхүүнээ худалдан борлуулахад тавигдах шаардлагыг бүрэн хангаж ирэх.

**“ШИНЭ УРГАЦ-2023” ҮЗЭСГЭЛЭН  
ХУДАЛДААНЫ ЖУРАМ**

2023.08.30  
хот

Чингис

**Нэг. Зорилго**

Монгол улсын Засгийн газрын 36 тогтоол “Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн төвийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг хангах, аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах.

**Хоёр. Тавигдах шаардлага**

1. Үзэсгэлэн худалдаанд оролцож буй иргэн аж ахуйн нэгж нь өөрийн орон нутгийн хөрсөнд тарьж ургуулсан бүтээгдэхүүнээр оролцох ба үйл ажиллагаагаа сурталчилсан самбар, үзүүлэн бэлдэж ирнэ.

2. /Plant.mofa.gov.mn/ цахим хаягт бүртгүүлж 2023 оны тариалалт, хураалтын мэдээг оруулсан байна.

3. Худалдан борлуулах бүтээгдэхүүн нь /plant.mofa.gov.mn/ цахим хаягаар дамжуулан гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулсан, гэмтэл согоггүй, өвчин, хортон шавьжид нэрвэгдээгүй органик бүтээгдэхүүн байна.

**Гурав: Шалгаруулах журам, шагнал**

1. Сум бүр үзэсгэлэн худалдаанд оролцох шилдэг нэг ногоочны тодорхойлолт материалыг 2 хоногийн өмнө ирүүлсэн байна.

2. Сумаас ирүүлсэн материалыг комиссын гишүүд үзэж танилцан шилдэг ногоочныг тус тус шалгаруулан өргөмжлөл мөнгөн шагналаар шагнана. /шалгуур үзүүлэлтэд тариалсан талбайн хэмжээ, тарималын нэр төрөл, хураан авсан ургац, өмнөх оны ажлын үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ/

3. Чанар стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтой даршилж боловсруулсан жимс, жимсгэнэ, даршилж боловсруулсан хүнсний ногоог тус тус шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

**Дөрөв. Бусад**

Үзэсгэлэн худалдаанд оролцох иргэн, аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүний нөөцтэй, худалдан борлуулахад шаардагдах материалыг сайн хангаж ирнэ.

**“НЭГ СУУРИН - НЭГ БҮТЭЭГДЭХҮҮН”  
ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ЖУРАМ**

2023.08.30

Чингис хот

**Нэг. Зорилго**

Орон нутгийнхаа боломж, давуу талыг ашиглан байгальд ээлтэй, шинэ болон уламжлалт технологи, өрсөлдөх чадвар бүхий нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний санаачлагыг өрсөлдүүлэн шилдэг брэндийг шалгаруулж дотоод, гадаадын зах зээлд нэвтрүүлэх, орон нутгийн шилдэг брэнд /нэрийн/ бүтээгдэхүүнтэй болоход дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Үзэсгэлэн худалдаанд оролцоход  
тавигдах шаардлага**

1. Үзэсгэлэн худалдаанд оролцох аж ахуйн нэгж, иргэд нь стандартын сав баглаа боодолтой эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
2. Өөрийн бараа бүтээгдэхүүний шинж чанар, давуу талуудыг тодорхойлсон танилцуулга, үзүүлэн самбар зэргийг бэлдэж нийтэд дэлгэн үзүүлэх
3. Шинэ санаа, хүний эрүүл мэндэд ээлтэй ЭКО чанарыг агуулсан байна.
4. Ижил төрлийн бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад онцлог шинжээрээ ялгарахуйц буюу хэрэглэгчийн таашаалд нийцэхүйц байх

**Гурав. Шалгаруулах журам, шагнал**

Дээрх шаардлагыг хангасан шилдэг Мод, модон эдлэл, Гар урлал болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүн, Оёмол бүтээгдэхүүн, Арьс ширэн эдлэл, Брэнд бүтээгдэхүүний багц, Шинэ санаа шилдэг бүтээл зэрэг бүтээгдэхүүнийг шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

**Дөрөв. Тавигдах шаардлага**

Үзэсгэлэн худалдаанд оролцох иргэн, аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүний нөөцтэй, зах зээлд бүтээгдэхүүнээ худалдан борлуулахад тавигдах шаардлагыг бүрэн хангаж ирэх.